

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	8
2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
2.8.2. Богино хугацаат хөрөнгө оруулалт	8
2.8.3. Авлага.....	9
2.8.4. Урьдчилгаа	9
2.8.5. Урт хугацаат хөрөнгө оруулалт	10
2.8.6. Бараа материал	10
2.8.7. Үндсэн хөрөнгө.....	11
2.8.8. Өр төлбөр.....	12
2.8.9. Засгийн газрын хувь оролцоо.....	12
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	14
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
2.12. Шилэн дансны мэдээлэл	18
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	19
3. Менежментийн захидал.....	20
3.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал	20
3.2. Орлогын данстай холбоотой асуудал.....	21
3.3. Авлагатай холбоотой асуудал.....	22
3.4. Балансын данстай холбоотой асуудал.....	22
3.5. Тайлагналтай холбоотой асуудал.....	23
3.6. Тайлагналтай холбоотой асуудал.....	24
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	25
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	25
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	27
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	30
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	36

Товчилсон үгийн жагсаалт

АШУҮИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АМТИС	Ашигт малтмал, технологийн их сургууль
БТДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний төв
БСШУСС	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам
ДТҮЭХ	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн
ЕБ	Ерөнхий боловсролын
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ,	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар,
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ болон ОНӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СУИС	Соёл урлагийн их сургууль
СУГ	Соёл урлагийн газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СУДС	Соёл урлагийг дэмжих сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХБДС	Хөгжим бүжгийн дунд сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХААҮШУОНТ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
ХҮСТҮБ	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт үйлдвэрлэл, бизнесийн
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХҮИС	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
ЭШХ	Эрдэм шинжилгээний хүрээлэн



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД
Ё.БААТАРБИЛЭГ ТАНАА**

2020.04.24 № 1440
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- ✓ Өмнөх оны аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага хэрэгжилт хангалтгүй,
- ✓ Жилийн эцэст 19,896.5 сая төгрөгийн авлага, 1,561.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй,

Залруулагдаагүй нийт 80,590.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 14,884.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд Ё.Баатарбилэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах, авлага, өглөгийг баталгаажуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, балансын данс, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дугаар сарын 1-нээс 2020 оны 4 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дугаар сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, гэрээт аудитор М.Ганбаатар нар гүйцэтгэв.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дугаар сарын 3-ны өдрийн 1а/2020 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

БСШУСЯ-ны эрхэм зорилго нь *“хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсрол, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино”* гэж тодорхойлсон байна.

БСШУСЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь:

- ✓ сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;
- ✓ боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх;
- ✓ Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг шинэчлэх, өргөжүүлэх;
- ✓ шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлого, судалгааны боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлж, улс орны хөгжил, нийгмийн сайн сайханд чиглүүлэх;
- ✓ хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн соёл, урлагийн олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоо, соёлын өвийн хамгаалал, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
- ✓ судалгаанд суурилсан биеийн тамир, спортын олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний биеийн тамирын үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх;
- ✓ салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, яамны төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;
- ✓ Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээг чанаржуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлэх зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь салбарын хэмжээнд БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн, салбар тус бүрийн онцлогийг тусган нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

БСШУСЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2019 онд сайдын эрхлэх асуудлын хүрээний 22 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж өгч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 1,488,405.2 сая төгрөгийн 1 хувь буюу 14,884.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 156,480.4 сая төгрөг болж 4,504.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	42.0	25.0	(17.0)
Банканд байгаа бэлэн мөнгө	127,222.1	140,074.9	12,852.8
Хадгаламж	33,720.6	16,380.5	(17,340.1)
Дүн	160,984.7	156,480.4	-4,504.3
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	28,605.9	45,952.6	17,346.7
Төсөл / сан	634.1	1,455.9	821.8
ТӨҮГ	131,744.7	109,071.9	(22,672.8)
Дүн	160,984.7	156,480.4	-4,504.3

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл арилжааны банканд 92,804.2 сая, Төрийн сангийн харилцахад 47,165.6 сая, хадгаламжид 16,380.5 сая, Монгол банканд 105.0 сая, кассад 25.0 сая төгрөг байна.

Мөнгөн хөрөнгийн 69.7 хувь буюу 109,071.8 сая төгрөг төрийн өмчит үйлдвэрийн газрууд болон төрийн өмчийн их дээд сургуулиудад, 29.4 хувь буюу 45,952.6 сая төгрөг төсөвт байгууллагад, 0.9 хувь буюу 1,455.9 сая төгрөг төсөл хөтөлбөрт үлдэгдэлтэй байна.

Банканд байршиж буй 140,074.9 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 14,437.0 сая төгрөг байна

Хадгаламж дансанд ШУТИС 7,773.8 сая, МУИС 6,027.6 сая, АШУҮИС 2,179.1 сая, ХҮИС 400.0 сая төгрөгийн хадгаламж байна.

Төсвийн зарцуулагдаагүй урсгал төсвийн 19,781.6 сая, нэмэлт санхүүжилтийн 3,238.6 сая, нийт 23,020.2 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

2.8.2. Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 1,023.6 сая төгрөг болж 392.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас /төгрөг/	1,416.1	1,023.6	(392.5)
Дүн	1,416.1	1,023.6	(392.5)
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага /Боловсролын зээлийн сан/	1,416.1	1,023.6	(392.5)

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын дагуу оюутны хөгжлийн зээлийн зориулалтаар арилжааны банкуудад мөнгө байршуулж, үнэт цаасаар бүртгэсэн. Зээл олгож, үлдэгдэл хөрөнгө үнэт цаас дансанд бүртгэлтэй байна.

2.8.3. Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 256,943.9 сая төгрөг болж өмнөх оноос 20,352.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	410.9	385.4	(25.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага	14,508.1	20,370.2	5,862.1
Татаас, санхүүжилтийн авлага	11,914.2	4,600.3	(7,313.9)
Зээлийн хүүгийн авлага	1,487.8	29.0	(1,458.8)
Дансны авлага /ТӨҮГ/	368.1	915.3	547.2
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	1.5	0.8	(0.7)
Бусад авлага	11,146.1	11,807.5	661.4
Зээлийн авлага	196,754.4	218,835.4	22,081.0
Дүн	236,591.1	256,943.9	20,352.8
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	202,216.2	223,863.6	21,647.4
Төсөл / сан	3,711.8	249.3	(3,462.5)
ТӨҮГ	30,663.1	32,831.0	2,167.9
Дүн	236,591.1	256,943.9	20,352.8

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Боловсролын зээлийн сангаас дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцагчдад олгосон сургалтын төлбөрийг зээлийн авлага дансанд бүртгэж байна.

Боловсролын зээлийн сангийн авлагын 54,345.0 сая төгрөг нь 5 жилээс дээш насжилттай авлага байна.

2.8.4. Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 22,180.8 сая төгрөг болж 7,775.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	12,346.7	21,025.3	8,678.6
Урьдчилгаа тооцоо	2,058.5	1,155.5	(903.0)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	723.5	539.4	(184.1)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,147.2	498.1	(649.1)
Цалингийн урьдчилгаа	95.5	68.4	(27.1)
Томилолтын урьдчилгаа	92.3	49.6	(42.7)
Дүн	14,405.2	22,180.8	7,775.6

Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	10,831.9	19,133.7	8,301.8
ТӨҮГ	3,573.3	3,047.1	(526.2)
Дүн	14,405.2	22,180.8	7,775.6

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.5. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 100.0 сая төгрөгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт № 5. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас /төгрөг/	100.0	100.0	0.0
Дүн	100.0	100.0	0.0
Үүнээс: байгууллагын төрлөөр			
ТӨҮГ Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	100.0	100.0	0.0
Дүн	100.0	100.0	0.0

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Уг дансанд үнэт цаасаар бүртгэлтэй 100.0 сая төгрөг нь Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль 2004 онд Хөвсгөл усан зам ЖК-ийн 23,606 ширхэг хувьцааг худалдан авсан үнэт цаас байна.

2.8.6. Бараа материал

Бараа материалын эцсийн үлдэгдэл 25,868.6 сая төгрөг болж 1,438.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	5,145.2	5,000.7	(144.5)
Тусгай зориулалттай материал	4,853.0	4,487.8	(365.2)
Эм боох материал	292.2	512.9	220.7
Дуусаагүй үйлдвэрлэл	362.0	715.1	353.1
Бэлэн бүтээгдэхүүн	686.2	708.2	22.0
Хангамжийн материал	17,824.7	19,005.0	1,180.3
Бичиг хэргийн материал	761.9	776.6	14.7
Аж ахуйн материал	6,252.3	6,711.7	459.4
Сэлбэг хэрэгсэл	295.4	283.6	(11.8)
Түлш, шатах тослох материал	82.4	63.1	(19.3)
Барилгын засварын материал	243.4	236.3	(7.1)
Хүнсний материал	76.1	72.9	(3.2)
Бусад хангамжийн материал	10,113.2	10,860.8	747.6
Мал амьтад	411.9	439.6	27.7
Дүн	24,430.0	25,868.6	1,438.6
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	14,699.3	15,371.1	671.8
ТӨҮГ	9,730.7	10,497.5	766.8
Дүн	24,430.0	25,868.6	1,438.6

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын өсөлтийг байгууллагын төрлөөр авч үзвэл 11,400.2 сая төгрөгийг төрийн өмчит байгууллагын, 8,828.8 сая төгрөгийг төсвийн байгууллагын хөрөнгө нэмэгдсэн байна.

2.8.7. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1,030,907.1 сая төгрөг болж өмнөх оноос 258,474.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	621,088.9	641,423.7	20,334.8
Барилга, байгууламж, орон сууц	427,320.9	434,366.1	7,045.2
Авто тээврийн хэрэгсэл	3,218.5	3,902.7	684.2
Машин, тоног төхөөрөмж/компьютер/	56,868.7	62,799.3	5,930.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,902.7	17,418.4	515.7
Зам, гүүрийн байгууламж	2,552.5	1,621.1	(931.4)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	71,514.8	72,610.8	1,096.0
Бусад үндсэн хөрөнгө	3,707.0	3,437.9	(269.1)
Дуусаагүй барилга байгууламж	24,489.1	29,174.4	4,685.3
Ном	14,514.7	16,093.0	1,578.3
Биет бус хөрөнгө	1,134,532.7	875,504.5	(259,028.2)
Программ хангамж	9,734.1	6,899.1	(2,835.0)
Бусад биет бус хөрөнгө	1,124,798.6	868,605.4	(256,193.2)
Дүн	1,755,621.6	1,516,928.2	(238,693.4)
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	1,289,381.9	1,030,907.2	(258,474.7)
ТӨҮГ	466,239.7	486,021.0	19,781.3
Дүн	1,755,621.6	1,516,928.2	(238,693.4)

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө бусад хэлбэрээр авсан 304,676.0 сая, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 253,475.5 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 18,290.5 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 17,556.9 сая, шилжүүлэн авсан 12,441.3 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 657.6 сая, нийт 607,097.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансас баланс шилжүүлсэн 593,835.2 сая, бусад хэлбэрээр хасагдсан 195,446.3 сая, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 21,050.9 сая, акталсан 7,513.1 сая, дахин үнэлгээний хорогдол 30.0 сая, худалдсан 8.5 сая, нийт 817,884.0 сая төгрөгөөр хасагдсан нь нөлөөлжээ.

Дуусаагүй барилга дансанд 29,174.4 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэний 89.4 хувь буюу 26,092.4 сая төгрөг АШУҮИС-д, 10.6 хувь буюу 3,082.0 сая төгрөг бусад байгууллагад бүртгэлтэй байна. Үүнд:

- АШУҮИС-ийн дүнд оюутны байр 10,247.8 сая, Монгол Японы цогцолбор эмнэлэг 7,479.6 сая, Номын сан 2,773.3 сая, Спорт цогцолбор 2,059.0 сая, Нүүр ам судлалын сургуулийн эмнэлэг 1,995.9 сая, Соёлын төв 1,085.0 сая, эмнэлгийн цогцолбор 448.2 сая, Эрхэс сувиллын 3.6 сая төгрөгийн барилгууд,
- Бусад байгууллагад ХААИС 1,502.0 сая, МУБИС 1,050.0 сая, ШУТИС 366.4 сая, МУИС 160.0 сая, ШУА 3.6 сая төгрөгийн дуусаагүй барилгууд,

2.8.8. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 55,139.9 сая төгрөг болж өмнөх оноос 3,353.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	22,483.6	23,585.4	1,101.8
Ажилчидтай холбогдсон өглөг	321.3	258.0	(63.3)
Бараа үйлчилгээний орлого	1,487.5	1,505.3	17.8
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	57.5	43.2	(14.3)
Зээлийн хүүгийн өглөг	4.6	4.0	(0.6)
Бусад өглөг	20,612.6	21,774.9	1,162.3
Байгууллагад төлөх өглөг	17,989.9	20,680.1	2,690.2
Хувь хүмүүст төлөх өглөг	2,021.8	112.3	(1,909.5)
Татварын өглөг /ТӨҮГ/	275.5	533.9	258.4
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	120.7	142.8	22.1
Дансны өглөг /ТӨҮГ/	204.7	305.8	101.1
Урьдчилж орсон орлого	28,949.3	31,200.7	2,251.4
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	427.5	377.7	(49.8)
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	12,724.7	15,154.1	2,429.4
Бусад урьдчилж орсон орлого	15,797.1	15,668.9	(128.2)
Урт хугацаат өр төлбөр	385.9	353.8	(32.1)
Урт хугацаат зээл	385.9	353.8	(32.1)
Дүн	51,818.8	55,139.9	3,321.1
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	15,597.3	18,583.3	2,986.0
Төсөл / сан	243.2	218.6	(24.6)
ТӨҮГ	35,978.3	36,338.0	359.7
Дүн	51,818.8	55,139.9	3,321.1

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 23,585.3 сая төгрөг буюу 42.8 хувийг богино хугацаат өр төлбөр, 31,200.7 сая төгрөг буюу 56.6 хувийг урьдчилж орсон орлого эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 61 хувь буюу 14,518.9 сая төгрөг Барилгын тухай хуулийн дагуу барилгын чанарын баталгаа /хуучин нэршлээр/-д байршуулсан хөрөнгө байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдлийн 30,761.5 сая төгрөг төрийн өмчит аж ахуйн нэгж /их сургууль/-ийн, төсөвт байгууллагын 439.2 сая төгрөг байна.

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн 65 төсөл арга хэмжээний 27,795.1 сая төгрөг, гүйлгээ хаагдсанаас шалтгаалан 14 төсөл арга хэмжээний 2,787.1 сая төгрөгийг хөрөнгийн барьцаа дансанд байршуулсан байна.

2.8.9. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,677,019.0 сая төгрөг болж, 535,288.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо данс

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	------------------------

Засгийн газрын хувь оролцоо	2,141,730.4	2,677,019.0	535,288.6
Засгийн газрын оруулсан капитал	253,585.4	253,383.6	(201.8)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	34,373.1	39,501.1	5,128.0
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,315.7	2,315.3	(0.4)
Хуримтлагдсан үр дүн	752,057.6	1,287,349.8	535,292.2
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	762,194.0	768,113.1	5,919.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	337,204.6	326,356.1	(10,848.5)
Цэвэр өмчийн дүн	2,141,730.4	2,677,019.0	535,288.6

Эх сурвалж: БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо 539,547.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 584,673.6 сая төгрөгтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,858,563.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,192,310.2 сая төгрөгийг урсгал зардалд, 616,453.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 49,800.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,857,600.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 5,963.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр, 5,000.0 сая төгрөгийн төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөхөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,778,498.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 79,102.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогджээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,141.2 сая төгрөг буюу батлагдсан төсвөөс 3,660.9 сая төгрөгөөр тасарсан, туслах үйл ажиллагааны орлогыг 3,651.1 сая төгрөг буюу 3,490.3 сая төгрөгөөр давсан нь орлогын төлөвлөлт, бүртгэлтэй холбоотой байна. Тухайлбал: Хөтөлбөр арга хэмжээний болон БТСГ орлогыг туслах үйлчилгээний орлогын ангилалд төлөвлөж, буруу бүртгэснээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,784,792.1 сая төгрөг буюу 96.0 хувьтай бөгөөд 73,771.8 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллын бүлгийн дүнгээр материаллаг дүнтэй дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

- Хөрөнгийн зардал 57,469.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь барилга байгууламжид 55,608.2 сая, их засварт 1,251.0 сая, тоног төхөөрөмж бэлтгэх зардлыг 610.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан;
- Засгийн газрын урсгал шилжүүлэх зардал 8,351.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсанд тус газрын 8,346.6 сая төгрөгийн дотоод шилжүүлэг нөлөөлж байна. Дотоод шилжүүлгийн дүнд Нийслэлийн тусгай зориулалт /СӨБ, ЕБС-ийн/-ын шилжүүлэг 5,888.3 сая төгрөг олгогдоогүй нь нөлөөлсөн;
- Бусад урсгал шилжүүлэг зардал 3,181.2 сая төгрөгөөр дутуу зарцуулалтад төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 2,535.8 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 485.7 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан

хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 153.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 6.6 сая төгрөг дутуу олгосон;

- Эргэж төлөгдөх зээл 2,752.5 сая төгрөг дутуу олгосонд оюутны хөгжлийн зээлийн квотыг сургууль бүрээр батлагдсанаас сургууль хооронд шилжүүлж зарцуулах боломжгүй, гадаадад суралцах оюутнууд гэрээний сунгалт хийгдээгүй;

Хөрөнгө оруулалтын нийт 603 төсөл арга хэмжээнд 616,453.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 558,983.8 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Ажил гүйцэтгэгч байгууллагуудад гүйцэтгэлээр 544,739.8 сая төгрөг шилжүүлж, БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтын дансаар дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээний чанарын баталгаанд 8,906.1 сая төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд, 5,337.8 сая төгрөгийг тус тус суутгаж захиалагчийн хяналтын дансанд шилжүүлсэн байна.

Үүнээс Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн боловсролын 51, соёлын 10, спортын 4, нийт 65 төсөл арга хэмжээний 20,840.2 сая төгрөгийг урьдчилгаа төлбөрийн баталгаагаар, боловсролын 27, соёлын 10, нийт 37 төсөл арга хэмжээнд 17,685.4 сая төгрөгийн хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Нэмэлт төсөв: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 7.6 сая төгрөг, хандив тусламжаар 4,953.3 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 21.2 сая, Засгийн газрын нөөц сангаас 4,479.4 сая, дээд шатны төсвийн захирагчаас 21,728.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,125.7 сая, нийт 43,308.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардал 42,153.9 сая, хөрөнгийн зардалд 790.3 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 371.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 98 төсвийн байгууллага, 18 төрийн өмчит аж ахуйн нэгж, 5 тусгай сан, нийт 121 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 115 байгууллагын санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, итгэл үзүүлсэн 4 байгууллага, аудитад хамрагдаагүй 2 байгууллагын санхүүгийн тайлан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 19 байгууллагыг түүвэрт хамруулж, 96 байгууллагад дүгнэлт хүргүүлжээ. Үүнд: “Зөрчилгүй” 81, Боловсролын зээлийн сан, Соёл урлагийг дэмжих сан, Говьсүмбэр аймгийн БСУГ, БСШУСЯ-ны аппарат, БТСГ, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал хамгааллын ЭШХ, Монгол Германы хамтарсан АМТИС, Шинэ эхлэл ЕБС, Нийслэлийн ЕБ-ын 29 дугаар сургууль, Уран зургийн галерей, Хархорин музей, ХҮСТҮБ-ийн корпорац ТӨААТҮГ зэрэг 13 байгууллага “Хязгаарлалттай”, Дорнод их сургууль, Нийслэлийн ЕБ-ын 116 дугаар сургуулийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 131,326.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 50,736.1 сая төгрөгийн алдааг залруулж, 108.9 сая төгрөгийн зөрчилд 46 төлбөрийн акт тогтоож, 46,208.6 сая төгрөгийн зөрчилд 87 албан шаардлага, 34,273.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 261 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- **Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд** бусад эргэлтийн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дүн, нийт хөрөнгийн дүн, хуримтлагдсан үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн дүн, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнг 4,258.9 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- **Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд** тусламж санхүүжилтийн орлого 2.147.1 сая, татварын бус орлого 108.9 сая, үйл ажиллагааны орлогын дүн 2.256.0 сая төгрөгөөр тус тус дутуу, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 38.1 сая төгрөгөөр илүү, үндсэн үйл ажиллагааны дүн 2,294.1 сая, үйл ажиллагааны бус зардлын дүн 2,076.3 сая, үйл ажиллагааны нийт үр дүн 217.8 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- **Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд** тайлант оны үр дүн 4,258.9 сая, 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдлийг 4,258.9 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- **Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд** татварын бус орлого 108.6 сая төгрөгөөр илүү, тусламж санхүүжилтийн орлого 111.6 сая төгрөгөөр дутуу, үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 3.0 сая төгрөгөөр дутуу, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 300.6 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 82.6 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 220.3 сая, хангамжийн бараа материалын зардал 1,315.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 5,597.8 сая, бараа үйлчилгээний бусад зардал 20.0 сая, татаас 4,281.1 сая төгрөгөөр тус тус илүү, томилолт, зочны зардал 10.2 сая урсгал шилжүүлэг 5,604.6 сая төгрөгөөр дутуу, хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн 2.9 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- **Төсвийн гүйцэтгэлийн тайланд** бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4,261.1 сая төгрөгөөр илүү, төрийн өмчит байгууллагат олгох татаас 4,261.1 сая, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 20.0 сая, бараа ажил үйлчилгээний зардал 20.0 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- **Нэмэлт санхүүжилтийн тайланд** нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, урсгал зардал, бараа, ажил үйлчилгээний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нэмэлт санхүүжүүлэлтийн орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсөв захирагчид хуваарилсан хөрөнгө 298.5 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Асуудал 1: Хариуцлага тооцуулах талаар

Төсвийн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Дорнод их сургууль, Нийслэлийн ЕБ-ын 116 дугаар сургууль “Сөрөг” санал дүгнэлт, Боловсролын зээлийн сан, Соёл урлагийг дэмжих сан, Говьсүмбэр аймгийн БСУГ, БСШУСЯ-ны аппарат, БТСГ, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал хамгааллын ЭШХ, Монгол Германы хамтарсан АМТИС, Шинэ эхлэл ЕБС, Нийслэлийн ЕБ-ын 29 дугаар сургууль, Уран

зургийн галерей, Хархорин музей, ХҮСТҮБ-ийн корпорац ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Дээрх байгууллагын албан тушаалтнууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-т “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл: Санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг 2, хязгаарлалттай 13 санал, дүгнэлт авсан төсвийн захирагч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг БСШУСС-д хүргүүлсэн.

Асуудал 2: Дотоод хяналтын талаар

Тус яамны ХШҮДАГ нь өмнөх аудитуудаар тавьсан төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй, үнэлээгүй, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7 дугаар зүйлийн 7.6-д “Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлыг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана”, 7.6.3-т. “холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц”, 7.6.4-т “хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц”, 7.6.5-д “аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл: Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, Тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 22,100.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 6 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

ШУА-д хийсэн аудитаар нийт 15,833.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 15,828.9 сая төгрөгийн алдааг залруулж, 4.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 98 байгууллагаас 4 байгууллагад итгэл үзүүлж, 17 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 66 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “БСШУСЯ-ны аппарат, БТСГ, Говьсүмбэр аймгийн БСУГ, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал хамгааллын ЭШХ, Монгол Германы хамтарсан АМТИС, Шинэ эхлэл ЕБС, Нийслэлийн ЕБ-ын 29 дугаар сургууль, Уран зургийн галерей, Хархорин музей зэрэг 10 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Нийслэлийн ЕБ-ын 116 дугаар сургуулийн санхүүгийн тайланд “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 10,023.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,196.1 сая төгрөгийн алдааг залруулж, 75.4 сая төгрөгийн зөрчилд 37 төлбөрийн акт тогтоож, 1,914.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 65 албан шаардлага хүргүүлж, 3,837.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 188 зөвлөмж өгсөн.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 18 аж ахуйн нэгж байгууллагаас 1 санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй, 14 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Дорнод их сургуулийн санхүүгийн тайланд “Сөрөг”, ХҮСТҮБ-ийн корпорацийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал, дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,968.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 721.4 сая төгрөгийн алдааг залруулж, 26.1 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 427.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 13 албан шаардлага хүргүүлж, 793.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 49 зөвлөмж өгсөн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 5 Засгийн газрын тусгай сангаас 1 санхүүгийн тайлан шалгагдаагүй, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 1, Боловсролын зээлийн сан, Соёл урлагийг дэмжих сангийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 51,766.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 355.3 сая төгрөгийн алдааг залруулж, 7.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 43,866.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 7.537.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 16 зөвлөмж өгсөн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар сайдын хөтөлбөр арга хэмжээний зардал, салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд нарийвчилсан горим, сорил гүйцэтгэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний 178 байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 26,652 мэдээллийг байршуулахаас 25,145 мэдээллийг хугацаанд нь, 6,945 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 507 мэдээллийг байршуулаагүй байна.

Хүснэгт №10 Шилэн дансанд БСШУСЯ-ны байршуулсан мэдээлэл /тоогоор/

№	Мэдээллийн нэр	Байршуулах шилэн дансны мэдээлэл		
		Нийт	Хугацаанд нь	Хугацаа хоцроосон
6.1.1	Тухайн жилийн төсвийн мэдээлэл	1	1	-
6.1.1	ОНХС-ийн төлөвлөгөө	1	1	-
6.1.2	Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл	4	2	2
6.1.3	Дараа жилийн төсвийн төслийн мэдээлэл	1	-	1
6.1.4	Санхүүгийн тайлан хагас болон жилийн эцсийн мэдээлэл	2	1	1
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	1	-	1
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	12	3	9
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээлэл	12	10	2
6.4.2	Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн мэдээлэл	12	11	1
6.4.3	Тендер, худалдан авалттай холбоотой мэдээлэл	12	11	1
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	12	9	3
6.4.5	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	12	6	6
6.4.6	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээлэл	12	8	4
6.4.7	Байгууллагын баталсан оронд орсон өөрчлөлтийн мэдээлэл	12	8	4
6.4.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүссэн аливаа шийдвэрийн мэдээлэл	12	10	2
6.10	Нийт албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдээлэл	12	11	1
Нийт дүн		130	92	38

Эх сурвалж: БСШУСЯ-ны шилэн дансны тайлан

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 281.4 сая төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоосноос 168.2 сая төгрөгийг барагдуулсан, 191,423.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 55 албан шаардлага хүргүүлснээс 7,977.4 сая төгрөгийн 23 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 209 зөвлөмж өгснөөс 127 зөвлөмжийг хэрэгжүүлж, 63 зөвлөмж хэрэгжих шатанд, 19 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 60.8 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” санал, дүгнэлт

Залруулагдаагүй 80,590.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 14,884.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” санал, дүгнэлтийг өгч байна.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

ШУТС, СУГ, ШУТИС, Улаанбаатар их сургууль, БМИҮЗ, БМДИ, ДТҮЭХ, Улсын хүүхэддэй театр, Нийслэлийн ЕБ-ын 29, 116 дугаар сургууль зэрэг байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь тухайн салбарын болон байгууллагын онцлогт тохироогүй, Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлт, хууль тогтоомж, заавар, журмын дагуу шинэчлэгдээгүй байна.

БСШУСС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд БСШУСС-ын 2017 оны А/40 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 -д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх, тухайн салбарын болон байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдахгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль тогтоомж, заавар журам, салбарын болон байгууллагын онцлогт нийцүүлэн шинэчилж мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.2. Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд тооцогдох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулахгүй, уг орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал: Шинэ эрин ЕБС, 30.9 сая, Монгол тэмүүлэл ЕБС 23.8 сая, Мал аж ахуйн ЭШХ 22.1 сая, Боловсролын хүрээлэн 4.0 сая төгрөгийн орлого байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсөв захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.4-т “ Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын 3.4-т “Энэ журмын 3.11-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно”, 3.4.3-т “үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол шинжтэй орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль журам заавар зөрчигдөх, төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй батлуулах, орлогыг бүрэн төвлөрүүлэх байх, үргүй зардал гаргах;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд тооцогдох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, дээд шатны байгууллагаар батлуулах, орлогын гүйцэтгэлийг зөв, бүрэн бүртгэж, төвлөрүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.3. Авлага, өглөгтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар 256,943.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд 24.129.8 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, 19,896.5 сая төгрөгийн авлагыг, 54,786.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэйгээс 1,561.6 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар дугаар зүйлийн 13-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-т “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Авлага, өглөг баталгаажихгүй байх, найдваргүй авлага үүсэх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, эзэн холбогдогчийг жагсаалтаар бэлтгэж гаргах, авлага өглөгийг баталгаажуулах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан болно.

3.4. Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сангийн дансаар дамжуулан зарцуулсан 312.3 сая төгрөгийн гүйлгээнд кассын тайлан бэлтгээгүй, сангаас сургалт, уулзалт, ажлын хэсэг, арга хэмжээний зардал, гэрээт ажлын төлбөрийг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон

хугацаанд тайлагнах” гэж заасантай, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журам зөрчигдөх, төсөв үр дүнгүй зарцуулагдах;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн болон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Жижиг мөнгөн сангийн дансны талаарх эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллах, түүнд тавих хяналтыг сайжруулах,

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.5. Тайлагналтай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Олимп, ДАШТ-ээс медаль авсан тамирчдад 1,533.8 сая төгрөгийн урамшууллыг олгосноос суутгагчийн хувь хүнд олгосон албан татварын тайланг 249.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д “урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 19 дүгээр зүйлийн 19.1.1-д “урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр”, 25 дугаар зүйлийн 25.1.4-д “энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд энэ хуулийн 21.2.2-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.5.2 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль хэрэгжихгүй байх, татвар төлөөгүйгээс торгууль алданги хүлээх,

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

3.6. Тайлагналтай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

БСШУСС, биеийн тамир спорт, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухааны 7 хөтөлбөр 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 31,238.6 сая төгрөгийн төсвийг баталжээ. Нийт 19,500.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээг түүвэрлэн үзэхэд хүүхэд харах үйлчилгээ, төмөр замын цэцэрлэгийн үйлчилгээ, урьд оны өр, боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зарцуулсан зардлын үр дүнг тооцоогүй, дүгнээгүй, мэдээ тайлан хангалтгүй байна,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 16.5.7-т “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 16.5.8-д “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Төсөв үргүй зарцуулагдах, түүнд хяналт алдагдах.

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн хуулийг хэрэгжүүлж, зардлын үр дүнг тооцож, мэдээ тайлан гаргаж байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтанд асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	437,827,137.8	1,219,389,571.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	160,984,701.8	156,480,373.6
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,416,114.8	1,023,644.8
33	АВЛАГА	236,591,131.7	256,943,874.8
34	УРЬДЧИЛГАА	14,405,208.6	22,180,849.8
35	БАРАА МАТЕРИАЛ	24,429,981.1	25,868,588.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	756,892,240.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,755,721,609.3	1,517,028,198.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000.0	100,000.0
37200	Үнэт цаас	100,000.0	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,755,621,609.3	1,516,928,198.7
39200	Биет хөрөнгө	621,088,920.8	641,423,691.6
39300	Биет бус хөрөнгө	867,525,524.9	875,504,507.1
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	267,007,163.6	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,193,548,747.1	2,736,417,770.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	51,818,761.6	55,139,863.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	51,432,835.7	54,786,043.7
41300	Өглөг	22,483,511.3	23,585,326.1
41400	Урьдчилж орсон орлого	28,949,324.4	31,200,717.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	385,925.9	353,819.6
42200	Урт хугацаат зээл	385,925.9	353,819.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,141,729,985.5	2,681,277,907.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,141,729,985.5	2,681,277,907.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253,585,391.8	253,383,558.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	34,373,152.6	39,501,094.1
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,315,269.4	2,315,269.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	762,193,984.1	768,113,134.1
51200	Хуримтлагдсан үр дүн	752,057,596.4	1,291,608,690.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	337,204,591.2	326,356,160.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,193,548,747.1	2,736,417,770.5

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,776,187,511.3	2,145,680,048.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	332,514,189.6	597,797,608.7
120	Нийтлэг татварын бус орлого	277,066,069.6	596,458,206.2
121	Хөрөнгийн орлого	0.0	108,273.9
122	Тусламжийн орлого	54,537,157.9	1,231,128.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	910,962.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,443,673,321.7	1,547,882,440.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,507,563,070.4	1,488,408,119.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,431,118,229.5	1,463,088,051.7

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,859,904.0	386,247,155.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,529,668.2	182,927,513.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,209,643.7	22,811,295.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,066,502.1	11,747,271.9
2104	Хангамж, бараа материалын зардал	37,651,108.6	8,438,676.4
2105	Нормативт зардал	1,648,600.6	1,787,579.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,288,672.7	6,661,988.4
2107	Томилолт, зочны зардал	3,911,460.3	4,180,600.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,970,851.1	50,207,027.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,583,396.7	97,485,202.9
211	ХҮҮ	437,612.5	115,777.3
212	ТАТААС	4,444,147.0	4,282,411.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,029,376,565.9	1,072,442,707.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	76,444,841.0	25,320,068.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	268,624,440.8	657,271,929.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,020,959.5	772,281.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	140,836,616.7	73,370,584.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	130,808,783.7	584,673,625.8

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,615,442,361.1	1,792,806,882.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	258,619,923.8	251,441,373.2
120	Нийтлэг татварын бус орлого	251,804,294.4	251,188,072.1
122	Тусламжийн орлого	5,907,052.4	1,065,272.7
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	908,577.0	188,028.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,356,822,437.3	1,540,365,508.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,396,402,417.4	1,463,557,708.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,396,402,417.4	1,463,557,708.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,042,556.9	381,042,906.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,277,329.5	182,552,723.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,705,065.0	22,854,039.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,716,244.4	12,293,868.1
2104	Хангамж, бараа материалын зардал	11,582,598.1	8,504,833.5
2105	Нормативт зардал	1,543,994.2	1,651,167.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,289,094.3	7,608,542.3
2107	Томилолт, зочны зардал	3,898,950.0	4,239,596.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,356,327.9	75,595,766.8
0	Бараа үйлчилгээний бусад зардал	46,672,953.4	65,742,368.2
211	ХҮҮ	12,044.3	12,550.6
212	ТАТААС	4,450,331.5	4,283,433.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,032,897,484.7	1,078,218,817.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	219,039,943.7	329,249,173.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	9,279.9	58,876.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	171,543,598.8	296,451,576.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	171,543,598.8	296,451,576.7

2200	Дотоод эх үүсвэрээр	170,599,158.8	296,451,576.7
2260	Гадаад эх үүсвэрээр	944,440.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-171,534,318.9	-296,392,700.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-31,167,786.7	-37,360,801.1
14	Бусад эх үүсвэр	5,155,663.4	2,173,469.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	32,450,994.0	37,340,224.9
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,872,456.1	2,194,045.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	16,337,838.2	-4,504,328.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	144,646,863.6	160,984,701.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	160,984,701.8	156,480,373.6

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	963,865,242.5	963,865,242.5
2	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт	40,050,626.9	40,050,626.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,003,915,869.4	1,003,915,869.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	169,867,997.0	169,867,997.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	837,095,815.2	837,095,815.2
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	41,520.2	41,520.2
9	Тайлант үеийн үр дүн	130,7808,873.7	130,808,783.7
11	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,141,729,985.5	2,141,729,985.5
12	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт	-45,127,881.9	-45,127,881.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,096,602,103.6	2,096,602,103.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-10,848,430.2	-10,848,430.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,845,258.0	10,845,258.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	5,441.6	5,441.6
18	Зарласан ногдол ашиг	-91.6	-91.6
19	Тайлант үеийн үр дүн	584,673,625.8	584,673,625.8
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,681,277,907.2	2,681,277,907.2

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,858,563,887.4	1,784,812,074.8	96.0	(73,751,812.6)
УРСГАЛ ЗАРДАЛ	1,192,310,186.2	1,178,780,743.0	98.9	(13,529,443.2)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,303,953.2	122,307,366.5	98.4	(1,996,586.7)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,397,664.5	53,705,770.1	98.7	(691,894.4)
Үндсэн цалин	41,669,514.5	42,489,431.0	102.0	819,916.5
Нэмэгдэл	8,497,459.6	7,346,231.0	86.5	(1,151,228.6)
Унаа хоолны хөнгөлөлт	2,338,692.9	2,097,939.1	89.7	(240,753.8)
Урамшуулал	1,891,997.5	919,311.6	48.6	(972,685.9)
Гэрээт ажлын хөлс	-	852,857.3		852,857.3

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,894,546.6	6,679,464.6	96.9	(215,082.0)
Тэтгэврийн даатгал	4,769,481.7	4,966,518.4	104.1	197,036.7
Тэтгэмжийн даатгал	536,259.5	473,636.9	88.3	(62,622.6)
ҮОМШӨ-ний даатгал	423,685.8	331,722.8	78.3	(91,963.0)
Ажилгүйдлийн даатгал	105,920.4	105,252.0	99.4	(668.4)
Эрүүл мэндийн даатгал	1,059,199.2	802,334.5	75.7	(256,864.7)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,987,209.6	3,862,531.3	96.9	(124,678.3)
Гэрэл, цахилгаан	1,140,533.2	1,222,610.0	107.2	82,076.8
Түлш, халаалт	1,543,244.3	1,405,425.4	91.1	(137,818.9)
Цэвэр, бохир ус	310,299.4	302,945.7	97.6	(7,353.7)
Байрны түрээс	993,132.7	931,550.2	93.8	(61,582.5)
Хангамж, бараа материалын зардал	1,476,634.4	1,435,183.5	97.2	(41,450.9)
Бичиг хэрэг	219,266.7	247,739.5	113.0	28,472.8
Тээвэр, шатахуун	333,404.8	313,897.6	94.1	(19,507.2)
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,430.0	321,616.0	90.5	(33,814.0)
Ном, хэвлэл	225,516.0	207,960.8	92.2	(17,555.2)
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,450.6	47,933.1	79.3	(12,517.5)
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,566.3	296,036.5	104.8	13,470.2
Нормативт зардал	358,648.9	281,047.8	78.4	(77,601.1)
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,850.0	18,117.1	101.5	267.1
Хоол, хүнс	248,801.0	175,640.5	70.6	(73,160.5)
Нормын хувцас, зөөлөн эдлэл	91,997.9	87,290.1	94.9	(4,707.8)
Эд хогшил, урсгал засварын зардал	1,108,641.9	1,084,172.7	97.8	(24,469.2)
Багаж, техник, хэрэгсэл	449,962.7	442,194.7	98.3	(7,768.0)
Тавилга	11,642.2	11,641.9	100.0	(0.3)
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,632.0	19,596.0	99.8	(36.0)
Урсгал засвар	627,405.0	610,740.2	97.3	(16,664.8)
Томилолт, зочны зардал	436,021.1	412,023.8	94.5	(23,997.3)
Дотоод албан томилолт	436,021.1	412,023.8	94.5	(23,997.3)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,528,584.1	43,998,725.9	97.6	(529,858.2)
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,077,051.8	43,650,427.7	99.0	(426,624.1)
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,127.0	102,186.0	92.8	(7,941.0)
Даатгалын үйлчилгээ	38,001.3	35,560.3	93.6	(2,441.0)
Тээврийн хэрэгслийн татвар	14,429.5	11,402.6	79.0	(3,026.9)
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,417.2	1,395.6	40.8	(2,021.6)
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	115,996.2	111,696.4	96.3	(4,299.8)
Газрын төлбөр	43,987.9	38,282.2	87.0	(5,705.7)
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	726.8	305.5	42.0	(421.3)
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	124,846.4	47,469.6	38.0	(77,376.8)
Бараа үйлчилгээний бусад зардал	11,116,002.1	10,848,437.8	97.6	(267,564.3)
Бараа үйлчилгээний бусад зардал	9,011,337.0	8,803,632.8	95.4	(207,704.2)
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,104,665.1	2,044,805.0	97.2	(59,860.1)
ТАТААС	4,281,091.0	4,281,091.0	100.0	
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,281,091.0	4,281,091.0	100.0	
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,281,091.0	4,281,091.0	100.0	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,063,725,142.0	1,052,192,285.5	98.9	(11,532,856.5)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,000,367,822.2	992,016,148.9	99.2	(8,351,673.3)
Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,000,356,776.7	992,010,131.5	99.2	(8,346,645.2)

Засгийн газрын гадаад шилжүүлэг	11,045.5	6,017.4	54.5	(5,028.1)
Бусад урсгал шилжүүлэг	63,357,319.8	60,176,136.6	95.0	(3,181,183.2)
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	37,473.0	37,159.0	99.2	(314.0)
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,206,396.9	20,670,576.7	89.1	(2,535,820.2)
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,691,824.8	21,206,157.5	97.8	(485,667.3)
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,165,018.7	18,011,924.5	99.2	(153,094.2)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	256,606.4	250,318.8	97.5	(6,287.6)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	616,453,701.2	558,983,867.6	90.7	(57,469,833.6)
Барилга байгууламж	581,870,001.2	526,261,792.9	90.4	(55,608,208.3)
Их засвар	25,845,500.0	24,594,470.1	95.2	(1,251,029.9)
Тоног төхөөрөмж	8,738,200.0	8,127,604.6	93.0	(610,595.4)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	49,800,000.0	47,047,464.2	94.5	(2,752,535.8)
Эргэж төлөгдөх зээл	49,800,000.0	47,047,464.2	94.5	(2,752,535.8)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,858,563,887.4	1,780,777,492.3	95.8	(77,786,395.1)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,857,600,906.7	1,778,498,029.7	95.7	(79,102,877.0)
Улсын төсвөөс санхүүжих	1,857,600,906.7	1,778,498,029.7	95.7	(79,102,877.0)
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,962,980.7	5,792,375.7	97.1	(170,605.0)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,802,182.9	2,141,246.9	36.9	(3,660,936.0)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,797.8	3,651,128.8		3,490,331.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(5,000,000.0)	(3,512,913.1)	70.3	1,487,086.9
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(5,000,000.0)	(3,512,913.1)	70.3	1,487,086.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,828,084.5		8,828,084.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	141,582.9		141,582.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	75,700	69,291	91.5	62,306
БАЙГУУЛЛАГЫН ТОО	92	92	100.0	32
Төсвийн байгууллага	92	92	100.0	32
АЖИЛЛАГСАДЫН ТОО	5,119	4,674	91.3	1,652
Удирдах ажилтан	137	137	100.0	44
Гүйцэтгэх ажилтан	4,074	3,691	90.6	1,267
Үйлчлэх ажилтан	908	846	93.2	341
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	65,370	59,851	91.6	58,969
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	59,761	59,472	99.5	58,789
Төрийн өмчит ЕБС	59,761	59,472	99.5	58,789
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,180	0		0
Төрийн өмчит СӨБ байгууллага	5,180	0		0
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	429	379	88.3	180
Төрийн өмчит МСҮТ	429	379	88.3	180
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5,119	4,674	91.3	1,653
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	541	514	95.0	194
Ажлын албаны албан хаагч (АА)	2	2	100.0	0
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	220	235	106.8	199
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1,682	1,576	93.7	228

Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1,229	980	79.7	407
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	313	305	97.4	96
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2	2	100.0	0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,061	993	93.6	464
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	100.0	0
УТҮГ	67	65	97.0	65

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,944,221.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,153,893.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,150,525.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,475,377.9
210101	Үндсэн цалин	4,966,122.7
210102	Нэмэгдэл	178,353.8
210104	Урамшуулал	513,088.1
210105	Гэрээт ажлын хөлс	817,813.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	619,120.0
210201	Тэтгэврийн даатгал	600,935.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,643.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,729.7
210204	Ажилгүйдлийн даатгал	834.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,977.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,368.3
210301	Гэрэл, цахилгаан	23,163.0
210302	Түлш, халаалт	15,953.9
210303	Цэвэр, бохир ус	1,200.0
210304	Байрны түрээс	28,051.4
2104	Хангамж, бараа материалын зардал	905,883.2
210401	Бичиг хэрэг	201,033.1
210402	Тээвэр, шатахуун	327,015.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,367.0
210404	Ном, хэвлэл	184,841.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,592.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	175,034.1
2105	Нормативт зардал	78,758.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	983.5
210502	Хоол, хүнс	50,662.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,112.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,030,950.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,006,748.9
210602	Тавилга	206,127.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	385.0
210604	Урсгал засвар	817,689.3
2107	Томилолт, зочны зардал	907,927.3
210701	Гадаад албан томилолт	104,106.3
210702	Дотоод албан томилолт	788,654.0

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	15,167.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,212,708.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,168,303.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,169.0
210807	Газрын төлбөр	6,032.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,625.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,851,432.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,548,389.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,303,043.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,003,367.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	763,875.5
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,986.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,046.7
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	4,752.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,792.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	723,297.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,239,492.2
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	833.1
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,238,659.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	790,327.9
2200	Дотоод эх үүсвэрээр	790,327.9
223001	Бусад хөрөнгө	774,920.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,407.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,308,161.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,308,161.5
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,953,237.2
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	21,197.5
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,479,392.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,728,624.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,125,709.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	363,940.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,624.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	371,564.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24 № 01/213
с.аг-2020/23/СТА-723

Улаанбаатар хот

Г Хариуцлага тооцуулах тухай Г

